

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ ҮГ ХЭЛЛЭГ, ДҮР ДҮРСЛЭЛИЙГ
НИЙТЛЭЛ ЗҮЙН ҮҮДНЭЭС НЯГТЛАН ЗАДЛАЖ ШИНЖИХ НЬ
/Шүүмж судлал/

Т.Баасансүрэн*

* Сэтгүүл зүйн судлаач, доктор, профессор

Түлхүүр үг: харьцуулал, яруу тод хэллэг, уран дүрслэл, хүүрнэн өгүүлэх нийтлэл, цэцэн мэргэн үгс, адилтгал зүйрлэл, “Монголын нууц товчоо”

“Монголын нууц товчоо” хөлгөн их сударт Монголын эзэнт гүрнийг үүсгэн байгуулалцах их үйл хэрэг болоод эзэн Чингис хаан, түүний хан хөвүүдийн үргэлжлүүлсэн байлдан дагуулалтад гар бие оролцож их бага, сайн муу ямар нэгэн байдлаар нэр холбогдсон 383 бодит хүний нэрс гардаг. Зарим хүний нэр ганц удаа, нөгөө зарим нь хэд хэдэн удаа, тухайлбал Чингис хааны нэр алдар 500 гаруй удаа давтагдах жишээтэй ажээ. Тэдгээр дотор бодит бус зохиомол нэр, зохиомол дүр нэг ч алга.

Тэрчлэн “Монголын нууц товчоо”-нд нийтдээ 673 газар нутаг, уул ус, улс орон, хот балгадын нэрс дурдагдаж буй. Эдгээр нэрс бүгд үнэн бодитой, олонх нь өнөөг хүртэл уугуул нэрээ хадгалсаар байгаа бөгөөд он цагийн урсгалд зарим газар ус, түүхт нутгийн нэр огших ба сунжрах, хувьсах ба

хувирах зэргээр аялга дуудлага нь өөрчлөгдөж шинэчлэгдсэн нь ч бас байна. Жишээ нь Бурхан халдун уулын нэр гэхэд 35 удаа давтагдаж байх жишээтэй билээ.

“Монголын нууц товчоо”-нд гарч байгаа дайн байлдаан, тулаанууд нь бүгд үнэн бодитой бөгөөд болж өнгөрсөн түүхэн үйл явдлууд болно. Манай цэргийн шинжээч эрдэмтэд гэхэд (Х.Шагдар зэрэг) Чингис хаан зөвхөн 1170-1206 оны хооронд тэр үеийн монголын газар нутаг дээр 19 тулалдаан хийснээс арван хоёрт нь дайснаа дарж, үлдсэн долоод нь бүрмөсөн мөхөөжээ гэдгийг баримтаар тогтоожээ.

Энэ бүгдийн тухай уран гоёор өгүүлж түүхэнд мөнхлөн үлдээсэн “Монголын нууц товчоо”-ны 12 дэвтэр дэх 282 зүйл бичвэрийн уран дүрслэлт бичлэгийг задлан нягталж үзвэл хүүрнэн өгүүлэх нийтлэлийн шинжийг агуулсан зураглал, тэмдэглэл, хөрөглөл цөөнгүй байх агаад домог туйлсын шинжтэй хэсгүүд, зүйр цэцэн үгс, яруу тансаг шүлэглэлээр чимэглэн баяжуулж утга агуулгыг улам гүнзгийрүүлэн баяжуул-

жээ. Бичлэгийн арга хэлбэр, зохиомж нь уран зохиолын гэхээсээ илүүтэйгээр нийтлэлийн өнгө аястай, түүхэн бодит үйл явдлыг тулгуур баганаа болгож тухайн цаг үеэ тольдон тусгаж үлдээсэн, өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн үндсэн гол зорилго болох үйл явдлыг үнэн бодитойгоор тусгах үүргийг үндсэн гол зорилгоо болгосон нь тод мэдрэгдэх ажээ.

“Монголын нууц товчоо”-нд сэтгүүл зүйн бичлэгт хамааруулж болох мэдээ, сурвалжлага, сурвалжилсан тэмдэглэл, ярилцлага, дуртгал тэмдэглэл, тэдгээрийн шинж тэмдгийг өөртөө агуулсан сэтгүүл зүйн бичлэгийн элементүүд бодитой байна. Энэ нь “Монголын нууц товчоо”-г нийтлэлийн дурсгалт бичиг гэж үзэх нэг үндэслэл болж байгаа юм. Энэ удаад миний бие “Монголын нууц товчоо” бүтээлийг:

Нэгдүгээрт: өвгөдийн үгийг өв болгож, хуучны үгийг хууль болгож явахыг хойч үеийнхэндээ сургаж гэрээлэж үлдээсэн нь (сургаал үгсийг хэрхэн яаж хэрэглэсэн байдал);

Хоёрдугаарт: монгол үгсийн сан хөмрөгөөс алтан сондор мэт адилтгал зүйрлэл, зүйр цэцэн үгсийг самран шүүрдэж сорчлон хэрэглэсэн нь;

Гуравдугаарт: шүлэглэсэн хүүрнэл, дүрслэлт үг хэллэгийн тухайд гэсэн гурван хэсэгт хувааж задлан шинжилж үзэв.

Энд судалгааны сүүлчийн 3 дахь хэсэгт хөндсөн 2 сэдвийн зөвхөн нэгийнх нь талаар өгүүлнэ. Өөрөөр хэлбэл шүлэглэлт хүүрнэлийн талаарх шинжлэлийг орхиод зөвхөн дүрслэлт үг, хэллэгийн байдалд хийсэн шинжлэлийг сугалан авч толилуулж байна.

“Монголын нууц товчоо”-г уншихад зөвхөн цэцэн мэргэн үгс, адилтгал зүйрлэл, айлтгал сургаалынх нь гүн гүнзгий утга агуулга зүрх сэтгэлийг жигүүрлүүлэн булиглуулах төдийгүй үг өгүүлбэр, хэл хэллэг бүр нь нүдийг соронздон татаж баяр баясал, бишрэл гайхшралыг зэрэг зэрэг төрүүлнэ. Сартай шөнийн тэнгэрт од мичид жирвэлзэн гялтганах адил ончтой, одтой үгийг олж байрлуулж шигтгэн өгчээ. Баримт түшиж ярья.

“Монголын нууц товчоо”-ны 55 дугаар зүйлд Өэлүн үжин өөрийг нь авч яваа сүйт нөхөр Их Чилэдүд “Тэр гурван хүний учрыг мэдэв үү чи? Тэдний царай сэжиглэмээр байна. Чиний аминд хор хүргэж болно. Амьд мэнд үлдвэл эхнэрийг олоход бэрхгүй. *Мухлаг тутам охид бий. Тэрэг тутамд хатад бий.* [Миний мэт өнгөт эхнэр олдоно. А.То] Хэрэв намайг санавал дахин авсан гэргийг миний нэрээр нэрлэгтүн. Одоо амиа арчил. Миний үнэрийг үнсч яв гээд цамцаа тайлж өгөв” гэжээ. Өнгөц гүйлгэн үзвэл МНТ-ны 282 зүйлийн ганцхан хэсэг нь, болж өнгөрсөн үнэн бодит үйл явдал. Өнгийн дотогш ухан харж чадвал хүний амьдралын замд тохиосон бүхэл бүтэн том драм. Өгүүллэг, тууж, роман болгон өрнүүлж гүнзгийрүүлж болох аугаа уран санаа. Түүнийг үл өгүүлж хоёрхон өгүүлбэрийн зургаахан үгийг онцолж уншигч таны анхааралд хандуулья. *Мухлаг тутам охид бий. Тэрэг тутамд хатад бий* гэжээ. Шүлэг шиг, адилтгал зүйрлэл шиг чихэнд наалдацтай содон сонсогдож байна. Сонсогдоод зогсохгүй нүдэнд бүр дүрслэгдэн бууж байна. Хамгийн гол нь

утга санааг гайхалтай тод илэрхийлжээ. Үүнийг монгол үг хэллэгийн гайхамшиг гэж нэрлэлтэй. “Монголын нууц товчоо”-г унших тутам улам илүү олон шинэ зүйлийг олж ухаардаг. Ахин дахин унших явцад надад нэг сэтгэгдэл төрж улмаар итгэл үнэмшил болж хувирсан. Энэ бол *монгол үг уран дүрслэлтэй ажээ, эх хэлний маань үг бүр нь, өгүүлбэр хэллэг бүгд нь өөртөө дүр дүрслэл, утга агуулгыг зэрэгцүүлэн агуулдаг юм байна* гэсэн бодол юм.

Мухлаг тутам охид бий. Тэрэг тутамд хатад бий гэсэн зургаахан үгтэй энэ хоёр өгүүлбэр дүрслэлт хэл хэллэгийн нэг тод жишээ биз. Энэ бол толгой холбосон шүлэг биш, бас монголчуудын ахуй амьдралын явцад тогтож хэвшсэн цэцэн мэргэн үг, адилтгал зүйрлэл ч биш юм. Монгол түмэн эрт дээр үеэс хацар гоо үзэсгэлэнт охид хатдаар элбэг баян байсан гэсэн санааг л илэрхийлэн хэлж байна. Өэлүн үжин Их Чилэдүд миний мэт өнгөт эхнэр олдоно гэж тэр санаагаа улам лавшруулан ухуулж байна. Дараагийн жишээг иш татья. МНТ-ны 57-р зүйлд “Амбагай хаан баригдаад Хадаан Хутула хоёрыг нэр заасан тул хамаг монгол, тайчууд нар Хорхонагийн хөндий гэдэг газар цугларч хэлэлцээд Хутулыг хаан болгов. Монголын жаргалан нь бүжиг хурим бүлгээ. Хутулыг хаан өргөмжлөөд *Хорхонагийн*

саглагар модны дор хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл дэвхцэн бүжиглэж хуримлав” гэжээ.

Хорхонагийн саглагар модны дор хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл дэвхцэн бүжиглэж хуримлав гэхээс илүүтэй бөгөөд амттайгаар хэн хэрхэн яаж дүрслэн буулгаж чадах билээ. Хутулыг хаан ширээнд өргөмжлөөд хамаг монголчууд, тайчууд

их найр хийж ёслон тэмдэглэснийг уран зурагт өнгө будгийг тохируулж хээлж дүрслэн буулгах адил үгийн чадлаар утгын донжийг нэгтгэн нийлүүлж чимэглэн чимхүүрдэж ийнхүү бичиглэн үлдээсэн байна.

Ийм дүр дүрслэлтэй үг хэллэгээр “Монголын нууц товчоо” далай баян юм. Уг

бүтээлийн 77-р зүйлд өөрийг нь харваж алахаар нум сум онилж хоёр талаас нь гэтэн ирэх Тэмүжин, Хасар хоёрыг хараад Бэгтэрийн хэлж байгаа “...*та нар намайг яаж нүдний сормуус, амны бөөлжис болгоно*” гэж буй хэсэг, 82-р зүйлд усны харигт нуугдаж хэвтэх Тэмүжинд “*Ах дүү тайчууд нар ам шүдээ билүүдэж айсуу явна. Чи хатуужин хэвтэж бай*” хэмээн Сорхоншарын хэлж буй үгс, түүнчлэн 87-р зүйлд тэр нэгжүүлийг одсон хойно Тэмүжинд хандан “*Намайг үнсээр хийсгэн алдав чи. Одоо даруй эх ба дүү нарын зүг яв*” гэж байгаа, 93-р зүйлд найман шарга морины эрэлд хамт явалцан анд нөхөд бололцож дасалцсан Тэмүжин, Боорчи хоёрыг

«
**“Монголын нууц товчоо”-нд
сэтгүүл зүйн бичлэгт
хамааруулж болох мэдээ,
сурвалжлага, сурвалжилсан
тэмдэглэл, ярицлага, дуртгал
тэмдэглэл, тэдгээрийн шинж
тэмдгийг өөртөө агуулсан
сэтгүүл зүйн бичлэгийн
элементүүд бодитой байна**
»

“Наху баяны гэрт хүрвэл хөвүүнээ алдав гэж нус нулимс болж байсан Наху баян, хөвүүнээ ирснийг үзээд нэг уйлж, нэг загнаж “Хөвүүн минь юу болсноо хэл гэвэл Боорчи үгүүлрүүн: “Энэ сайн нөхөр мунгинаж явахыг үзээд хамт одсон билээ. Одоо ирэв” гээд мордож, хээр боож тавьсан намбух суулгаа авч ирэв. Тэмүжинд тэд тэлээ хурга алж хүнс бэлтгээд бас ганзгын тулам өгөв. Наху баян үгүүлрүүн: “Хоёр залуус үүнээс хойш сайхан нөхөрлө, бие биеэ битгий орхи” гэв. Тэндээс Тэмүжин мордож гурван өдөр, гурван шөнө яваад Сэнгүр горхинд байгаа гэртээ хүрэв. Тэмүжинг ирэхэд Өэлүн эх, Хасар хийгээд дүү нарын зовиол тайлагдаж сэтгэл баясае” зэрэг нь бүгдээрээ дүр дүрслэлт үг, хэллэгийн барим тавим баримт жишээ мөн болно.

Та нар намайг яаж нүдний сормуус, амны бөөлжис болгоно гэсэн Бэгтэрийн үгэнд ахан дүүсдээ өширхөж бас итгэж ядан гоморхсон гашуун гомдол, ах дүү тайчууд нар ам шүдээ билүүдэж айсуу явна гэх өгүүлбэрт Тэмүжинг эрж олох л юм бол юу ч хийхээс буцахгүй улайрсан олон дайсны аяг ааш, намайг үнсээр хийсгэн алдав чи гэсэн Сорхоншарын үгэнд үхтлээ айж сандарч үнэнээ хэлж бачимдаж сандарсан түүний өнгө зүс харагдаж, дуу хоолой сонсогдох шиг болж байна. Нус нулимс болж байсан Наху баян, хүүгээ ирснийг үзээд нэг уйлж, нэг загнаж байгаа нь харагдах шиг болж байна. “Зовиол тайлагдаж сэтгэл баясае” гэсэн дөрөвхөн үгнээс Өэлүн ээж, Хасар нарын сэтгэл тэнийж жаргасан нь шууд мэдрэгдэнэ. Энэ бол утга агуулгыг гойд

тодорхой олж илэрхийлсэн ончтой үг өгүүлбэрийг байх ёстой байршилт газарт нь зандан модон унь, тооно, баганын заадсыг нийлүүлэн шаантаглаж зоож урласантай яг адилхан бөлгөө.

МНТ-ны 97 дугаар зүйлд Бурхан халдун уулнаас Урианхайн Жарчиудай өвгөн төмрийн дарханы үлээж хийлж халаадаг тулман хөөргөө үүрч, Зэлмэ нэртэй хөвүүнээ дагуулж Чингис хааныг Бүрги эрэгт нутаглан байхад нь хүрч ирээд миний хөвүүн Зэлмээр “Эмээлээ тохуул, үүдээ сөхүүл” хэмээн тушааж өгч буй, 98-р зүйлд Хуагчин эмгэн үүр цүүрээр яаран сандран босч “Эх, эх үтэр бос. Газар дэлбэрэх мэт чимээ гарч, морин төвөргөөн сонсдоно. Аймшигт тайчууд айсуу биз. Эх даруй бос” гэж байгаа, 108-р зүйлд болзоот цагаас гурав хоног хожимдож ирсэн Тэмүжин, Тоорил, Жаха хамба нарт “Бороо тохиолдовч болзооноос хождохгүй, хур тохиолдовч хурлаас саатахгүй гэж монгол үгээр хэлэлцэж “За” гэж андгайлсан биш билүү? “За” гэсэн цагаас хожидсон этгээдийг зэрэг дотроос хасъя гэсэн биш билүү?” гэж Жамухагийн хэлж буй, тэрчлэн 121-р зүйлд Хорчи ирж Чингис хаанд “Бид Бодончар богдын барьж авсан эмээс төрсөн тул Жамухатай хэвэл нэгтэй, хэлхээ бэхтэй хүмүүс билээ. Иймийн тул Жамухаас хагацаж болохгүй” гэж учирлаад заарин тэнгэр ирж нүдэнд минь зааж үзүүллээ гээд тэнгэр газар эелдэж Тэмүжинг улсын эзэн болтугай гэв гээд ярьж буй хэсгийн зарим үг хэллэгүүд эрдэнийн гэрэлт шигтгээ адил утгыг улам ялгаруулан тодотгож дүр дүрслэлийг үлэмж тансаг, торгомсог болгож байна гэж хэлмээр байна.

“Эмээлээ тохуул, үүдээ сөхүүл” гээд Зэлмээ хөвүүнээ хаанд тушааж өгч буй Жарчиудай өвгөний үгэнд түүний бодит төрх байдал, үйлс хэрэгт хүүтэйгээ хамт буцаж няцашгүй идэвхийлэн тэмцэх хандлага, эзэндээ үнэнч чанар товойн гарч байна.

Газар дэлбэрэх мэт чимээ гарч, морин төвөргөөн сонсдоно гэсэн хэллэгийг уншихад дэвсгэр ширдэг өндөлзөж, дээвэр туурга дэндэлзэх шиг л болж байгаа юм. Дээрх өгүүлбэрийг Д.Цэрэнсодном нарын орчуулгад “Газар доргилж, төвөргөөн сонсдоно” гэж буулгасан байдаг. Доргилж гэдэг нь дэлбэрэх гэдгээс дээр болсон байж болох ч морин гэсэн үгийг авч хаясан нь илүүдсэн байж болзошгүй.

“*Бороо тохиолдовч болзооноос хождохгүй, хур тохиолдовч хурлаас саатахгүй гэж монгол үгээр хэлэлцэж “За” гэж андгайлсан биш билүү?* “За” гэсэн цагаас хожидсон этгээдийг зэрэг дотроос хасъя гэсэн биш билүү?” гэсэн Жамухийн эл үгнээс их цэргийг жолоодогч монгол жанжны эрс шийдэмгий зан чанар, төрх байдал харагдаж, хэлсэн амандаа хазайлгүй хүрч байхын зайлшгүйг эрхгүй мэдрүүлнэ. “За” гэвэл “ёогүй” гэсэн монгол үг хэллэг чухам эндээс буй болсон ч байж мэдэх юм. XII зууны сүүлч, XIII зууны эзэнт монгол гүрнийг байгуулах гайхамшигт үйлсийг гардан манлайлагчид, дайчин цэрэг эрс нь чухамхүү “За” гэвэл “ёогүй” чин зоригт, шударга ариун, эрэлхэг зоригтнууд байжээ. Монголын “за” гэдэг үг андгай тангараг гэсэн утгаар чихэнд сонсогдож, сэтгэлд дүрслэгдэн бууж байна. “*Жамухатай хэвэл нэгтэй, хэлхээ бэхтэй хүмүүс билээ*” гэсэн үг

хэллэг ч гэсэн мөн нэгэн адил нүдэнд онцгойрон торж, сэтгэлд зурагдан дүрслэгдэж байна.

Бас МНТ-ны 131-р зүйлд Морины уяаны цулбуурын хулгайчаас болж Бүрибөх, Бэлгүтэй хоёр ам муруйн хэрэлдэж улмаар “Бэлгүтэйн нүцгэн мөрийг Бүрибөх илдээр хага цавчив. Бэлгүтэй ингэж цавчигдсан боловч, огт ажиггүй цусаа цувриулж явахыг, сүүдэрт суугаад хуримлан байсан Чингис хаан үзэж гарч ирээд үгүүлрүүн: “Хэнд ингэж цавчигдав” гэхэд Бэлгүтэй үгүүлрүүн: “Өглөө ийм болсон билээ. Миний бие ялаарь байна. Ах дүү нар сая ижилдэн найрамдаж байгаа тул миний төлөө ах битгий муудалц, хоромхон байзна гэв” хэмээсэн цөөн хэдхэн өгүүлбэрт их том үйл явдлыг тоймлон базаж өгүүлжээ. Эндээс эрэлхэг, гүжирмэг эр Бэлгүтэйн дүр төрх тодрон дурайж буй. Ах дүү, амраг садны эв эе, найрамдалт харилцааг юу юунаас илүүтэйгээр хайрлан чухалчилж, өөрийн бие, ирт элдийн шархыг юманд эс санан алхаж яваа нь харагдана. Дөнгөж эвлэлдэн нэгдэж ойртон дотносож буй ахан дүүс надаас болж муудалцах болуузай гэж ихэд эмээж байгаа нь эрхгүй мэдрэгдэнэ. Түүнийг Жүрхэний Бүрибөх илдээр хага цавчив гэсэн гуравхан үгтэй эл өгүүлбэрт болсон үйл явдал, маргаан хэрүүлийн үр дагаварыг нүдэнд харагдаж толинд буулгах адил тод томруун дүрслэн үзүүлж чадсан байна. Цөстэй эрсийн ширүүн зодолдоон болсныг үүнээс өөрөөр яаж товч тодорхой хэлэх билээ.

МНТ-ны 141-р зүйлд “Түүний хойно, тахиа жил (1201 онд) хатиган салжиуд хамтаар, Багу чорхи тэргүүтэй хатагин

нар, Чирхитэй баатар тэргүүтэй салжиуд нар... Алхуй булаг гэдэг газар чуулаад жажирдай овгийн Жамухыг хан өргөмжлөхөөр хэлэлцэж *азарга гүүг алж андгайлан тангаргалаад* тэндээс Эргүнэ мөрөн рүү нүүж Эргүнэд цутгах Хан мөрний шанаагийн Агуу нугад Жамухыг гүр хан болгож өргөмжлөв. Жамухыг гүр хан (бүгдийн хан) өргөмжлөөд Чингис хаан Ван хан хоёртой байлдахаар мордъё гэлцэв” гэжээ. *Азарга гүүг алж андгайлан тангараглаад* гэсэн энэ таван үгнээс Жамухыг гүр ханд өргөмжилсөн үйлдэл ёслолын үйл ажиллагаа ямархуу сүр дуулиантай болж өнгөрсөн нь мэдрэгдэж байна.

МНТ-ны 148-р зүйлд “Чингис хаан, тэнд тайчуудыг довтолж Аучу баатар, Ходун орчин, Худуудар зэргийн тайчуудын язгууртныг *ургийн ураг хүртэл үнсэн товрог болгож хядав*. Улс иргэнийг нь нүүлгэж, Чингис хаан, Хубахаяа (Ухаа хаяа) гэдэг газар ирж өвөлжив” хэмээн гардаг. Мөн 149-р зүйлд Ширээт өвгөн өөрийн хөвүүн Алаг, Наяа хоёртой элбэж Таргудай-Хирилтугийг ойд хоргодож байхад нь олж барьж аваад тэргэн дээр суулгаж Чингис хаан руу явахад түүний хөвүүд, дүү нар нэхэн булааж авахаар араас нь хүрч ирдэг. Ширээт өвгөн Таргудайг хөлбөрүүлэн унагаж, гэдсэн дээр нь сандайлж суугаад хутгаа сугалж “Хөвүүд, дүү нар чинь чамайг булааж авахаар ирэв. Хан чамайг одоо би эс алавч, чамд нэгэнт халдсан тул намайг алах болно. Чамайг алавч нэгэн адил алагдах болно. Иймийн тул *чамаар дэр хийж үхье*” гэж хутгын ирийг Таргудайн хоолойд тулгавал...” хэмээн гардаг. Таргудай-Хирилтуг өөрийн хүүхдүүд,

дүү нартаа Ширээт өвгөн намайг алчихвал та нар миний хүүрээр юу хийнэ. Буцагтун, Чингис намайг алахгүй. Ачийг санаж амь хэлтрүүлэх биз гэж *их дуугаар уйлан хэлж* буцаадаг билээ. Ширээт өвгөн Наяа эзнээ амьдаар барьж аваачиж өгвөл Чингис хаан эзэндээ халдав гэж алах биз. Бидэнд үл итгэнэ гээд Таргудай-Хирилтугийг тавьж явуулаад үнэнийг хэлж өөрсдөө хүчээ хаанд өгөхөөр хүрч ирэв гэдэг билээ. Түүнийг нь Чингис хаан үнэлэн дотночилсон тухай өгүүлдэг.

Өөрийн өрсөлдөгч дайснаар Ширээт өвгөн *дэр хийж үхье* гэжээ. Энэ үг МНТ-нд хэдэнтээ, тухайлбал 154-р зүйлд бас гардаг. Их зөвлөлдөөнөөр хэлэлцэж тохиролцсон чанд нууцыг Бэлгүтэй Татаарын Их Чэрэнд ам алдсанаас улбаалж олон татаарууд хүн бүр “*дэр авч үхье*” гэж хэлэлцэж манай цэргүүд их хохирол амссан тухай гардаг. Энд бас их дуугаар уйлан хэлсэн тухай тодотгож байна. “*Дэр хийж үхье*” гэж их дуугаар “*уйлан хэлэв*” зэрэг эдгээр үг хэллэг нь үйл явдлын дүр дүрслэлийн бодит жишээ мөн.

МНТ-ны 152-р зүйлд Тоорил ханыг харь нутагт зовж зүдэрч туйлдаж явсныг Ван ханы дүү ноёдын яриагаар “...*таван ямаа шөрөглөн сааж* (ямааг дэлэвчлэх буюу ишигний хошууг шөрөглөн), *тэмээний цус ханаж идсээр ганц сохор халиун морьтой*, Тэмүжинд ядаж ирвэл, Тэмүжин хөвүүн, гувчуур татаж түүнийг тэжээв. Гэтэл одоо тэр ингэж явснаа мартаад *өмхий элэг өвөртөлж явна* гэж хэлэлцэв” хэмээн өгүүлжээ.

Таван ямаа шөрөглөн сааж, тэмээний цус ханаж идсээр ганц сохор

халиун морьтой хүрч ирэхэд хэмээжээ. Эл өгүүлбэрээс туйлдаж ядарч тартагтаа тулсан Ван ханы өрөвдөлтэй дүр зураг харагдах аж. Гэтэл тэгж явснаа тэрбээр мартаад *өмхий элэг өвөртөлж явна* гэж бодит үнэнийг сөргүүлэн тавьж, хүн чанараа гээгдүүлснийг нь зэвүүцэн тодотгожээ. *Өмхий элэг өвөртөлж* гэж маш хүчтэйгээр товойлгон дүрслэж өгүүлсэн байна.

МНТ-ны 166-р зүйлд Жамуха Тоорил вангийн хүү Нялха-Сэнгүмтэй уулзаад Тэмүжин Таян хаантай үргэлж харилцаатай байдаг. Түүнд итгэж болохгүй. Та нар Тэмүжинтэй байлдахаар мордвол би хажуунаас нь оролцъё гэж хатгахад Алтан, Хучар хоёр уухайлан дэмжиж Өэлүн эхийн өнчин хөвүүдийн **ахы нь алж, дүүгий нь дүүжилж өгье** гэж ам гарахад Өвгөжин ноён **гары нь барьж, хөлий нь хүлж өгье** хэмээсэн тухай, тэдний үг ятгалгыг сонсоод Тоорил ван “Арга сүвэгчилж Тэмүжиний улсыг булааж авъя. Улсаа автал тэр яах ч аргагүй болно” гэж зөвшөөрөхөд Хачиу бэхи Нялха-Сэнгүм чиний төлөө **уртын үзүүрт, гүний ёроолд хүрэхээс буцахгүй** гэж андгайлдаг.

МНТ-ны 167-р зүйлд дээрх сэдвийг улам гүнзгийрүүлэн зангидаж өрнүүлээд Жамуха болоод төрсөн хүүгийнхээ үгэнд Тоорил ван **нэг итгэж нэг эргэлзэж байна**. Тэр Тэмүжин хөвүүнд муу юм санаж яаж болно, тэнгэр биднийг таалахгүй. Жамуха хэзээнээс **тэнэмэл чалчаа** хүн билээ. Тэр дэмий зөв буруу үг хэлж байна гэхэд хүү Сэнгүм нь “Одоо чамайг амьд байхад биднийг тэр тоомсорлохгүй байна. Хэрэв хан эцэг чамайг **цагаан**

идээнд цацаж, хар маханд хахвал, Хурчахус-Буйруг хан эцгийн зовж хураасан улс, зүдэж байгуулсан төрий чинь бидэнд мэдүүлэхгүй болуузай” гэж уурлаад үүд хаян гарч одоход Ван хан хөвүүнээ хайрлаж аргадан буцааж урьж ирүүлээд “Та нар чадах бол юу үйлдэхээ өөрсдөө мэдтүгэй” гэжээ.

Эдгээрээс та бид Тоорил ван ихэд эргэлзэн тээнэгэлзэж ацан шалаанд орж эцсийн шийдвэрийг гаргаж чадахгүй үймэрч хямарч байгааг харж болно. Нэг хэлэхдээ арга сүвэгчилж байгаад Тэмүжиний улсыг булааж авъя, тэгвэл тэр яах ч аргагүй болно гэж, нөгөө хэлэхдээ Тэмүжин хөвүүнд муу санаж яаж болно, тэгвэл тэнгэр биднийг таалахгүй гэж, ахиад арга мухардахдаа та нар чадах бол юу үйлдэхээ өөрсдөө мэдтүгэй хэмээн зөнд нь хаяж байх жишээтэй. Эндээс ван хан Тоорилын халшрамтгай, гуйвамтгай, туйлбаргүй байдал илүү тод мэдрэгдэнэ.

МНТ-ны 173-р зүйлд гарч байгаа “Өгэдэйн хүзүү, суманд шархатсан тул Борохул, түүний **асгарсан цусыг амаар шимж, зангирсан нөжийг завьжаар цувируулж** ирэв”. Чингис хаан үзээд “нүднээс нулимс цувируулж сэтгэлээ зовж, даруй гал түлүүлээд шархыг хайрч” хэмээснээс **асгарсан цусыг амаар шимж, зангирсан нөжийг завьжаар цувируулж** гэсэн 8 үгийг, 174-р зүйлд Монголын олонх Жамуха, Алтан, Хучар нарыг дагаж бидний энд бий. Тэмүжинг дагаж гарсан монголчууд хаана холдох вэ? Морин унаатан, модон нөмөртөн болов тэд. Тэднийг дагаж эс ирвэл бид очиж, **морины хомоол мэт хормойлж авч**

ирье гэлээ гэсэн мэдээг Чингис хаанд хүргэж ирсэн Ачиг-Ширүний мэдээллээс **морины хомоол мэт хормойлж авч ирье** гэсэн 6 үгийг, түүнчлэн 187-р зүйлд гарч байгаа “Бас Чингис хаан, Ван хааны суудаг алтан асар, хэргэлэдэг алтан завьяа аяга ба **асгарч явсан ард сэлт**, вангийн хажууд бараа болооч хэрэйд цөмийг Бадай Хишилиг хоёрт олгож

Хувьдаа зарцалж

Хундгаа бариулж

Хоромсгоо зүүлгэж

Ургийн урагт хүртэл

Удтал дархлан жаргатугай, та хоёр хэмээсэн хэсгээс **асгарч явсан ард сэлт** гэсэн 4 үгийг, МНТ-ны 193-р зүйл дэх “Монголын цэргүүд **Саарь хээрийг дүүртэл буужээ. Өдөр бүр ундрах ус шиг нэмэн ирж байх бололтой.** Одноос олон гал ноцож байна” гэж Найманы харуулаас өөрийн хан Таянд мэдүүлсэн мэдүүлгээс **Саарь хээрийг дүүртэл буужээ. Өдөр бүр ундрах ус шиг нэмэн ирж байх бололтой** хэмээсэн 13 үгийг тус бүрийг онцлон авч дүр дүрслэлт үг хэллэгийн тоонд хамааруулж болох мэт санагдана.

Чингис эзэн хааны их сууринд суугаад хамтран зүтгэлцэж Их Монгол Улсыг байгуулалцсан шадар сайдууд, сайн нөхдөө хөхиүлэн сайшааж шагнал соёрхол хүртээсэн тухай хэсгүүдэд сэтгэл уярам, зүрх булгилам дүр дүрслэлт үг хэллэгүүд маш олон байна. Тухайлбал МНТ-ны 204-р зүйлд Чингис хаан Мэнлиг эцэгт хандан хэлж буй “Ван эцэг, Сэнгүм анд хоёр намайг мэхэлж урьсанд очих замдаа Мэнлиг эцгийн гэрт хоновол, чи намайг ятгасангүй бол **хар усанд живж, халуун галд түлэгдэж үхэх**

билээ би”. Тэр тусы чинь сэтгэж, ургийн урагт хүртэл үүрд мартаггүй”, 205-р зүйлд насан туршийн үнэнч анд нөхөр Боорчид хандан “**Насан бага цагт найман шарга морио алдаад гурван хоног нэхэн явах замд** чамтай уулзсан билээ... чи гэртээ харьж, эцэгтээ хэлэлгүйгээр гүүний айрагтай суулгаа хээр орхиж, **миний оготор хонгор морийг юулж, орог шинхул морийг надад унуулаад** өөрөө хурдан ухаа морио унаж, адуугаа эзэнгүй орхиод яаравчлан надтай бас гурван хоног дээрэмчдийг нэхсэн билээ... Чи Наху баяны ганц хөвүүн бөгөөд юу мэдэж надтай нөхөрлөсөн билээ. **Чи үнэн сайхан сэтгэлээр нөхөрлөв.** Түүний хойно чамайг санасаар явж, би Бэлгүтэйг илгээж нөхөрлөө гэвэл, чи **бөгтөр хонгороо унаж, бор өрмөг хэвнэгээ нөмөрч** өөрөө хүрч ирэв... Далан нөмрөгт татаартай тулалдаж хоноход **өдөр шөнө үргэлж хур зүсрэн оров.** Тэр шөнө намайг унтуулах гэж нөмрөгөө надад нөмөргөөд, миний дээр борооны усыг дуслуулахгүйгээр шөнө турш зогсохдоо **чи өрөөсөн хөлөө ганц удаа сольж гишгэсэн билээ.** Хүлэг баатрын шинж энэ мөн. Түүнээс хойшх чиний зүтгэлийг алийг хэлж барах вэ? Боорчи, Мухулай хоёр, **зөв явдлы минь зөвшөөрөн тэтгэж, буруу явдлы минь буцаан зогсоож** энэ их сууринд хүргэв. Одоо бүгдийн дээр суулгаж, есөн удаа осол гаргавч ял хэлэлцэхгүй болгоё” гэжээ.

Эхний зүйл дэх **хар усанд живж, халуун галд түлэгдэж үхэх билээ би** гэсэн өгүүлбэрээр Мэнлиг эцгийн их гавьяаг товойлгон тодотгожээ. Ийм тийм үгээр ингэж тэгж ятгаж

ухааруулав гэж тоочсонгүй. Харин хаан эзнийг хар усанд живж, халуун галд түлэгдэж үхэх аюулаас аврав гэж үнэлсэн байна. Эзэн хаанд ингэж үнэлэгдсэн хүн эрхэм суудалд сууж элдэв хэрэг явдлыг шийдвэрлэлцэхэд оролцох эрх дархтай бололгүй яахав.

Анд нөхөр Боорчийнхоо гавьяа зүтгэлийг үнэлэхдээ эзэн хаан үг огтхон ч харамласангүй. Үйл хэргийг нь нүдэнд амилан харагдаж, сэтгэлд хоногшин үлдтэл урамтай сайхнаар дүрслэн өгүүлжээ. **Насан бага цагт найман шарга морио алдаад гурван хоног нэхэж явах замдаа тааралдахад оготор хонгор морийг минь юулж, орог шинхул морийг надад унуулаад** гэх зэргээр нэхэн дурсаад **чи үнэн сайхан сэтгэлээр надтай нөхөрлөв.** Сүүлд нөхөрлөө гэж Бэлгүтэйг илгээхэд **чи бөгтөр хонгороо унаж, бор өрмөг хэвнэгээ нөмөрч** өөрөө хүрч ирэв. Татаартай тулалдаж хээр хоноход өдөржин шөнөжин зүсэрсэн бороонд намайг унтуулах гэж нөмөргөө надад нөмөргөөд, өөрөө борооны усыг дуслуулахгүй гэж халхавчлан зогсож хоноход **өрөөсөн хөлөө ганц удаа сольж гишгэсэн** гэжээ. Түүнээс хойшх аль зүтгэлийг чинь хэлж барах вэ. Боорчи, Мухулай хоёр **зөв явдлы минь зөвшөөрөн тэтгэж, буруу явдлы минь буцаан зогсоож** залж чиглүүлэлцэж явсаар намайг их сууринд авчирч суулгав. Есөн удаа осол гаргавч авч хэлэлцэхгүй өршөөл болгоё гэжээ. Үүнээс илүү өндөр үнэлэлт гэж юу байхсан билээ. Шөнөжин зогсохдоо өрөөсөн хөлөө ганц удаа сольж гишгэсэн хүлэг сайн баатар эрийнх нь хүнлэг шинж чанар,

тэсвэр хатуужлыг тавхан үгэнд багтааж дүрсэлж тодорхойлжээ.

МНТ-ны 249-р зүйлд Тангуд буюу Хашин улсыг байлдахаар Чингис хаан хүрч очиход эзэн хаан Бурхан нь Чага нэртэй охиноо өгч, “Баруун гар чинь болж хүчээ өгье” хэмээгээд тангудууд бид бол байсан газартаа байран нутагладаг, шавар хотдоо шавалдан суудаг, хүмүүс тул хурдан аянд түргэн хөдөлж чадахгүй, хурц дайнд даруй мордож амжихгүй. Тиймээс өндөр дэрсний нөмөрт өсгөж үржүүлдэг тэмээгээр өргөл барья гэж учирлаад хэлсэн амандаа хүрч буй тухай өгүүлдэг. Тэр тухай “Тангуд иргэнээс тэмээ татварлаж **тууж барахгүй олон тэмээ** авчирч өгөв” хэмээжээ.

МНТ-ны 251-р зүйлд “...Чингис хаан, Дүн гүан боомтыг хүрвэл **Хятадын цэргүүд уулыг бүрхэж, хөндийг бялхаж байна...**” гэжээ. 280-р зүйлд “**Охор шидэмс дутуулбал уруулын хагасыг огтолно. Халбага хигээс дутуулбал хамрын хагасыг огтолно**” гэж Өгэдэй хаан зарлиг болов гэж гардаг. 281-р зүйлд “Доголхуг далдаас хардсан нэг буруу бий. Ямар буруу вэ гэвэл, **хаан эцгийн минь харах нүдний өмнө, хамгаас түрүүнд хатгалдаж явсан** Доголхуг хорт муу үгэнд орж хороожээ. Одоо миний өмнө хэн тэгж тэргүүлэн давшиж өгөх вэ? Хаан эцгийн минь өмнө зүтгэсэн журамт хүнийг мэдэхгүйгээр өшөөлснийг өөрөө би буруушаана” гэжээ.

Тууж барахгүй олон тэмээ авчирч өгөв гэхээр ямар олон тэмээ вэ гэсэн ойлголт өөрийн эрхгүй уншигчдын сэтгэлд бууж таарна. **Хятадын цэргүүд уулыг бүрхэж, хөндийг бялхаж байна** гэсэн энэ өгүүлбэрээс

тоо томшгүй, айж сүрдэм олон цэргийн бараа сэтгэлд дүрслэгдэж буухгүй байхын аргагүй. **“Охор шидэмс дутуулбал уруулын хагасыг огтолно. Халбага хигээс дутуулбал хамрын хагасыг огтолно** гэхээр хааны зарлигийн хатуу ширүүн хууль, дүрэм журам шууд мэдрэгдэж байна. **Хаан эцгийн минь харах нүдний өмнө, хамгаас түрүүнд хатгалдаж явсан Доголхуг...** Одоо миний өмнө хэн тэгж тэргүүлэн давшиж өгөх вэ? гэсэн Өгэдэй хааны үгэнд хийсэн хилсдүүлэлдээ хэмжээлшгүй ихээр харамсаж гэмшсэн дүр төрх илрэн гарч байна.

Утга агуулгыг ийм ончтойгоор олж товойлгож илэрхийлсэн үг хэллэгийг би сая живаа өвсөн толгойд үүрийн гэгээнээр үерлэн тогтож буугаад өглөөний нарны шижир алтан туяанд солонгорон мэлтэрч молорлон бөнжигнөсөн шүүдрийн мянга түмэн дусалтай адилтган зүйрлэх хүсэлтэй байна. “Монголын нууц товчоо”-н дахь адилтгал зүйрлэл, цэцэн мэргэн үгсийг шижир алтан сондорын цоморлиг мөн гэж үзэх юм бол агуулга хийгээд утгыг түүнээс дутахгүйгээр илэрхийлэн гаргаж дүрслэн үзүүлж чадаж байгаа эдгээр үг хэллэгийг эх монгол хэлэнд минь хан тэнгэрээс асгаран буусан мөндрийн мөнгөн дуслууд мөн бусуу гэж дуу алдан хэлмээр байна. Энэ бол монгол үгс дүр дүрслэлтэй, өвөг дээдсээс бидэнд өвлүүлж үлдээсэн эх монгол хэл минь эгшиглэнтэй, сонсголонтой бөгөөд хөгжимлөг, уран дүрслэлт хэл хэллэг мөн болохыг батлан харуулж буй баримт юм.

Шүүдрийн мянган дуслыг нэг нэгээр цуглуулах адил эх хэлнийхээ эрдэнэ-

сийн дундаршгүй арвин уурхайгаас үгийн хүдрийн дээжийг ширхэг ширхгээр шүүрдэж байгаад “Монголын нууц товчоо”-г өвөг дээдэс минь урлан бүтээж чадсан нь юутай гайхамшиг. Бас юутай бахархалтай. Еншөөбүү овогт Бямбын Ринчен гүүш

Чихэну чимэг болсон аялгуу сайхан монгол хэл

Чин зоригт өвөг дээдсийн минь өв их эрдэнэ

Сонсох бүр яруу баялгийг гайхан баясаж

Сод их билэгт түмэн юугаа бишрэн магтмуу би гэж санамсаргүй ч нэг хэлчихээгүй ажээ. “Монголын нууц товчоо” нь монгол хэлний бяра тэнхээг бялхуулж, монгол үгсийн сангийн хэл хэллэгийн алтан сондор, мөнгөн мөндрийг түүж цуглуулж түүвэрлэж туурвисан үүрд мөнхийн үнэнхүү нандин судар бичиг мөн болой. Энэ бол нийт бичгийн хүмүүс, тэр дотроос нийтлэлчдийн хувьд биенээсээ салгалгүй авч явж, ахин дахин уншиж судалж, бүтээл туурилдаа бүтээлчээр дуурайж хэрэглэж байх ёстой ширээний ном юм. Учир юу гэвэл зохиолч, сэтгүүлчдийг үгийн урлагийн мастерууд гэдэг билээ. Жинхэнэ үгийн урлагийн үлгэр дууриал, үнэн бодит үйл явдлыг тэмдэглэж үлдээсэн бичлэгийн шилмэл загвар бол “Монголын нууц товчоо” мөн гэдэгт эргэлзэх явдалгүй биз ээ.

“Монголын нууц товчоо”-нд гарч байгаа шиг дүр дүрслэлт үг хэллэгийг өнөө үеийн нийтлэлчид бүтээл туурвилдаа хэрэглэх нь өдрийн од шиг цөөрчээ. Гэхдээ бас ганц нэг байна. Жишээ нь “Үндэсний тойм” сэтгүүлд нийтлэгдсэн геологич Н.Тэгшбаярын

“Таталцал нууцлаг үзэгдэл” хэмээх эрдэм шинжилгээний хялбарчилсан нийтлэлд орчлон ертөнц дэх таталцлын зүй тогтлыг Эйнштейний харьцангуйн онолоор тайлбарлаж од, галактикуудын хязгааргүй мэт үргэлжлэх орон зай биес хоорондын таталцлын долгионы нөлөөгөөр мурилдаг болохыг 2015 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 9 цаг 45 минутад АНУ-ын Луизиан мужид байрладаг тусгай лабораторид бүртгэж авснаа 2016 оны 2 дугаар сарын 11-нд зарласан тухай өгүүлжээ. Тэр дотор “Таталцлын долгион нь бидний орон зайг дайрч өнгөрөхдөө манай дэлхийг өчүүхэн бага хэмжээгээр **устай гүзээ шиг цэлцэгнүүлээд** өнгөрсөн ажээ”¹ гэсэн байна. Физикч Н.Тэгшбаяр сэтгүүлчдээс илүү уран онож хэлжээ. **Устай гүзээ шиг цэлцэгнүүлээд** өнгөрсөн гэсэн энэ өгүүлбэрт таталцлын долгион дэлхийгээр дайраад өнгөрсөн нь нүдэнд харагдах шиг болж байна. Дүрслэлт үг хэллэгийн ид шид гэдэг энэ юм.

Олон жилийн өмнө сэтгүүлч Б.Ганчимэг сумогийн их аварга Д.Дагвадоржтой хийсэн ярилцлагадаа Асашёроюүгийн зан авир, дотоод шаталт, тэсрэлтийг товойлгож гаргахын тулд Японы сумогийн дэвжээнд та “**азаргалсан**” шүү дээ гэсэн үг хэрэглэж өдөж байгаад яриулсан байдаг. Хаанчилсан, түрэмгийлсэн гэсэн утга санааг монгол ахуй амьдралтайгаа холбож “**азаргалах**”² гэдэг үгээр илэрхийлж байгаа нь энэ. Монголчуудад, ялангуяа малчин түмэнд бол энэ нь зураглан буулгаж байгаатай яг адилхан. Их ойр дөт, сэтгэл зүрхэнд шууд наалдаж бууна.

1989 онд Бажуудайн Ганбат “Эх” хэмээх эссе бичиж “Үнэн” сонинд нийтлүүлсэн билээ. Дотроо 10 хэсэгтэй. “Эхийн бүүвэй” хэмээх эхний хэсэгт ах дүү хоёр баатар охин дүүгээ адуучин эртэй сууж хүүхэд төрүүллээ. Бидний дүү охины нөхөр хүлэг сайн баатар байх ёстой хэмээн маргалдаж улмаар маргаанаа ирт мэсийн хүчээр шийдвэрлэхээр эрсэлдэн тэмцэлдсэн тухай өгүүлдэг. Ахуй, домгийн шинжтэй эл хүүрнэлд охин дүү нь үрийн бүүвэй аялж ах нараа эвлэрүүлж тайтгаруулж байгаа тухай гардаг. Тэнд “**Алаг нүдэндээ нулимс мэлмэрүүлэн, мэлтэлзүүлэн бүүвэйлжээ**” гэсэн нэг өгүүлбэр бий. Энэ өгүүлбэрийг уншаад би элбэрэлт эхийнхээ дүрийг харах шиг, эгшиглэнт бүүвэйн дууг нь сонсох шиг тийм хүчтэй мэдрэмж төрснөө огт мартдаггүй юм. **Мэлмэрүүлэн, мэлтэлзүүлэн** гэсэн энэ хоёр үг эх хүний гүн их хайр энэрэл, үрээ гэсэн үлэмжийн хүчит үнэнхүү сүүн цагаан сэтгэлийг гайхалтай тодоор илэрхийлэн буулгаж байгаа юм. Хүүгээ бүүвэйлэв гэх юм уу, эсвэл уйлж байгаад бүүвэйлэв гэсэн бол сэтгэлд огт хүрэхгүй. **Мэлмэрүүлэн, мэлтэлзүүлэн** бүүвэйлэв гэхээр нүдэнд харагдаад ирж байгаа юм.

Устай гүзээ шиг **цэлцэгнүүлээд** гэх буюу эсвэл адуу малтайгаа холбож **азаргалаад** гэж хэлэхэд, алаг нүдэндээ нулимс **мэлмэрүүлэн мэлтэлзүүлэн** бүүвэйлэв гэхэд уншигч танд эрхгүй нэг юм бодогдож байгаа биз? Нийт сэтгүүлчид уг нь үг, өгүүлбэрийг ингэж шигтгэж шижиртүүлж бичмээр байгаа юм.

ДҮГНЭЛТ

XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийн Монголын эзэнт гүрний үүсэл төлөвшил, мандал бадрал, Чингис хаан, түүний хан хөвүүдийн байлдан дагууллын үнэн бодит түүх, тухайн цаг үеийн онцгой чухал үйл явдлыг хураангуйлж охилон дээжилсэн нийтлэлийн хосгүй нандин дурсгалт бичиг болох “Монголын нууц товчоо”-нд сэтгүүл зүйн бичлэгт хамааруулж болох мэдээ, сурвалжлага, тэмдэглэл, ярилцлага, дуртгал тэмдэглэл, зураглал, хөрөглөл хийгээд тэдгээрийн шинж тэмдгийг өөртөө агуулсан элементүүд элбэг баян байгааг миний бие өмнө нь тодотгон баримтаар баталж «“Монголын нууц товчоо” — нийтлэлийн дурсгалт бичиг мөн»³ хэмээх номыг уншигчдад 2014 онд хүргэсэн билээ.

“**М**онголын нууц товчоо”-ны бичвэрүүдийн утга агуулгыг улам нарийвчлан судалж үг хэллэг, дүр дүрслэлийн байдлыг нь нийтлэл зүйн үүднээс нягтлан задалж шинжилж үзэхэд дараах үндсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. “Монголын нууц товчоо” бол алтан ургийнхны аж төрөх ухааны алтан сургаалын эрдэнийн хэлхээс мөн ажээ. Өөрөөр хэлбэл дэлхийг донсолгосон хүчирхэг эзэнт гүрнийг байгуулахын төлөөх эцэг өвгөдийн минь урт удаан хугацааны турш хийсэн тэмцэл тулалдааныг хураангуйлж дээжилсэн түүхэн үнэний товчоон болой. Эзэн Чингис хаан, түүний хан хөвүүдээс хойч үедээ үлдээсэн захиас гэрээслэлийн гэрэлт ариун цоморлиг буюу төрт ёс хийгээд төр барихуйн ухааны их нэвтэрхий толь бичиг гэж

нэрлэлтэй. Эдүгээгийн хэл хэллэгээр бол төр нийгмийг түвшитгэн жолоодох монгол үндэстний “Хар хайрцаг”-ны бодлогын уг үндэс, язгуур эхлэл нь энд байна. “Өвгөдийн үгийг өв болгож, хуучны үгийг хууль болгож яв” хэмээн “Монголын нууц товчоо”-нд сургамжлан захиж гэрээсэлж үлдээжээ.

2. Найман зууны тэртээх монгол ардын аман ярианы болоод бичгийн зохиолын хэл хэллэг дэх цэцэн мэргэн үгсийг “Монголын нууц товчоо”-нд хамгийн арвинаар оруулж яруу сайхнаар гүйцэд ашиглан бүтээлээ туурвижээ. Тэдгээрийг агуулгаар нь шинжилж үзэхэд сургаал үгс, ард түмний аж байдлын цэцэн мэргэн үгс, хорвоо ертөнц, хүмүүний амьдралыг илэрхийлсэн гүн ухааны цэцэн үгс, нийгэм-улс төрийн утга агуулгатай цэцэн үгс гэх зэргээр дотор нь хэд хэд ангилан үзэж болохоор ажээ. Энэ нь “Монголын нууц товчоо”-г найман зууны тэртээх монгол ардын үгсийн сангийн далай баян бүтээл мөн болохыг маргашгүйгээр батлан харуулж байна.

3. Ардын хэл яриан дахь адилтгал зүйрлэлийг “Монголын нууц товчоо”-нд дээд зэргээр чадмаг ашиглаж, түүгээрээ дамжуулан үйл явдал, үзэгдэл юмсын мөн чанар, утга агуулгыг гайхалтай ойлгомжтой тодоор илэрхийлэн гаргаж чаджээ. Чухам үүгээрээ уг бүтээл онцгойрон ялгарч байна.

4. “Монголын нууц товчоо”-ны хамгийн амт шимттэй тансаг хэсэг нь түүний шүлэглэсэн хүүрнэлүүд болно. Нийтдээ 1977 мөр буюу 4 мөртөөр бадаглабал 494 бадаг шүлэг оржээ. Агаар тэнгэрт саран авхайг

байрлуулаад, түүнийгээ тойруулж од мичдийг ойр ба холд олж ончтойгоор байршуулан шигтгэх мэт шүлэглэлт хүүрнэлээр донжийг олон баяжуулж сартай шөнийн сайхан дүр зураглалыг урлан бүтээсэн мэт онцгой содон мэдрэмж, оргилсон бадрангуй сэтгэгдлийг өөрийн эрхгүй төрүүлэх аж. Эдгээр шүлэглэлт хүүрнэл нь “Монголын нууц товчоо”-г нар сар, навч цэцэг адил найрсуулан чимж байна.

5. Монгол хэл нь эгшиглэнтэй агаад сонсголонтой хөгжимлөг дүрслэлт үгээр, дүрслэлт хэл хэллэгээр дэндүү баян болохыг “Монголын нууц товчоо” барим тавим батлан өгүүлж байна. Шүлэглэлт хүүрнэл нь “Монголын нууц товчоо”-г нар сар, навч цэцэг адил найрсуулан чимж, адилтгал зүйрлэл нь алтан сондор адил гэрэлтүүлэн гийгүүлж байгаа бол дүрслэлт үг, дүрслэлт хэллэг нь мөнгөн мөндөр адил мэлтрүүлэн солонгоруулах ажээ.

“Монголын нууц товчоо”-г зохиогч (зохиогчид) нь торго нэхэх адил, тор сүлжих адил, зөгий үүрээ урлах адил зүмбэрлүүлэн угалзлуулан урлаж, сүндэрлүүлэн сүмбэрлүүлэн босгожээ. Хүүрнэн өгүүлсэн нь шүлэг найраг шиг эгшиглэнтэй, шүлэглэж адилтгаж толгой холбосон нь хайлах туульс, дуулах дууль адил сонсголонтой ажээ.

Эдгээр нь бүгдээрээ нийлж нэгдээд “Монголын нууц товчоо”-г XII-XIII зууны Монголын нийгэм, Монголын ард түмний тэмцэл тэмүүллийн түүхийг товч тодорхойгоор нийтлэл зүйн бичвэрээр бичиж тэмдэглэж үлдээсэн бичлэгийн сонгодог хэв загварыг бүрдүүлж өгч байгаагаараа онцгой ач холбогдолтой болно.

Тайлбар: “Монголын нууц товчоо”-г Ц.Дамдинсүрэн гуайн хөрвүүлгээр авсан болно. “Монголын нууц товчоо”, Улсын хэвлэлийн газар. 1976 он. Өгүүлэл дэх хар өнгөөр зурж тодруулсан нь зохиогч миний өөрийн тодотгол болой.

Ишлэл

¹ *Тэгшбаяр Н.* Таталцал нууцлаг үзэгдэл. “Үндэсний тойм” сэтгүүл. 2016, № 6, 7.

² *Баасансүрэн Т.* 2009. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь. УБ. 323 дахь тал.

³ *Баасансүрэн Т.* 2014. «“Монголын нууц товчоо” – нийтлэлийн дурсгалт бичиг мөн». УБ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Баасансүрэн Т.* 2014. «Сокровенное сказание монголов» — письменный памятник публицистики. УБ.

2. *Баасансүрэн Т.* 2009, 2010. Становление свободной демократической прессы в Монголии Тт. I-V. УБ.

3. *Гаадамба Ш.* 1990. Сокровенное сказание монголов. (Старомонгольская письменность, перевод и объяснения для смыслового изучения). УБ.

4. *Дамдинсүрэн Ц.* 1976. Сокровенное сказание монголов. УБ.: госиздательство.

5. *Лувсанданзан.* 1990. Алтан товч. УБ.: госиздательство,

6. *Норовсүрэн Л.* 2004, 2005, 2007. Публикации Монголии. Тт. I-III. УБ.

7. *Норовсүрэн Л.* 2013. Теоретические и исторические вопросы журналистики. УБ.

8. *Пэрлээ Х.* 1958. Поиск и нахождение названий мест, упоминаемых в «Сокровенном сказании монголов». УБ.

9. *Цэрэнсодном Д.* и др. 2004. Сокровенное сказание монголов. УБ.: изд-во «Болор судар».

10. *Чоймаа Ш.* 2011. Сокровенное сказание монголов (Новый перевод с

объяснениями старых слов и словосочетаний). УБ.

Резюме

В 2014 году автор опубликовал книгу «"Сокровенное сказание монголов" как образец публицистики». В пяти главах своей книги автор затрагивает актуальный вопрос возникновения и начала древней истории монгольской публицистики, представляет результаты своего многолетнего труда. Продолжая своё исследование "Сокровенного сказания монголов", автор рассматривает устную и

письменную формы сравнений, выражений и наставлений. Автор приходит к выводу, что слова в монгольском языке обладают необыкновенной выразительностью, сочностью и музыкальностью, доказательством чего является "Сокровенное сказание". На основании многочисленных примеров автор доказывает, что язык "Сокровенного сказания" более соответствуют публицистике, нежели литературному жанру. Автор убеждён, что "Сокровенное сказание" является уникальным культурным наследием наших отцов и дедов, и оно должно стать настольной книгой каждого монгольского журналиста.